

## ГАРЧИГ

|                                                                                                 |    |
|-------------------------------------------------------------------------------------------------|----|
| 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....                                                                | 1  |
| 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....                                                              | 1  |
| 1.2. Ордын нөөц.....                                                                            | 2  |
| 1.3. 2026 оны ил уурхайн төлөвлөлт .....                                                        | 2  |
| 1.3.1. Уулын ажлын одоогийн байдал.....                                                         | 2  |
| 1.3.2. Ашиглалтын технологи, горим.....                                                         | 3  |
| 1.3.3. Ил уурхайн гүн, хүрээ хязгаар .....                                                      | 3  |
| 1.3.4. Ил уурхайн хүчин чадал, уулын ажлын горим .....                                          | 4  |
| 1.3.5. Ил уурхайн элс олборлолтын хүчин чадал.....                                              | 4  |
| 1.3.6. Уурхайн ажлын горим .....                                                                | 4  |
| 1.3.7. Уулын ажлын өрнөл дараалал .....                                                         | 5  |
| 1.3.8. Хөрс хуулалтын технологи .....                                                           | 5  |
| 1.3.9. Олборлолтын технологи.....                                                               | 6  |
| 1.3.10. Уулын ажлын процессууд .....                                                            | 6  |
| 1.3.11. Овоолгын процесс.....                                                                   | 7  |
| 1.4. Баяжуулалтын технологи .....                                                               | 7  |
| 1.5. Дэд бүтэц .....                                                                            | 7  |
| 2. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....                                              | 9  |
| 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....                                                  | 12 |
| 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....                                 | 12 |
| 3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....                                                         | 15 |
| 3.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө .....                                    | 16 |
| 3.4. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө .....                                              | 16 |
| 3.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....                                         | 16 |
| 3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....                                              | 17 |
| 3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....                                                 | 19 |
| 3.8. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ .....                    | 21 |
| 3.9. Орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр .....                                                  | 22 |
| 3.10. “Тэр бум” мод Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний<br>төлөвлөгөө ..... | 26 |
| 3.11. БОМТ-ний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь .....              | 26 |
| 3.12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал .....                                | 27 |

## ХҮСНЭГТҮҮД

|                                                                                               |    |
|-----------------------------------------------------------------------------------------------|----|
| Хүснэгт №1. Тусгай зөвшөөрлийн талбайн солбилцол.....                                         | 1  |
| Хүснэгт №2. “Сөрт” алтны шороон ордын нөөцийн нэгдсэн тооцоо.....                             | 2  |
| Хүснэгт №3. Уулын ажлын механикжуулалтын бүтэц .....                                          | 3  |
| Хүснэгт №4. Ил уурхайн 2026 оны нийт уулын ажлын хэмжээ.....                                  | 4  |
| Хүснэгт №5. Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа.....                            | 4  |
| Хүснэгт №6. 2026 оны уулын ажлын төлөвлөгөө.....                                              | 5  |
| Хүснэгт №7. “Сөрт” ордын элс олборлолт /2026 он/ .....                                        | 7  |
| Хүснэгт №8. Элс угаалт бүтээгдэхүүн гаргалт /2026 он/.....                                    | 7  |
| Хүснэгт №9. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн сонголт .....                                    | 7  |
| Хүснэгт №10. Унд ахуйн болон технологийн усыг хангах гүний худгийн мэдээлэл .....             | 8  |
| Хүснэгт №11. Жилд шаарддагатай технологийн усны нийт хэрэглээ.....                            | 8  |
| Хүснэгт №12. Хоногт шаарддагатай технологийн усны хэрэглээ.....                               | 8  |
| Хүснэгт №13. Технологийн усан сангийн багтаамж.....                                           | 8  |
| Хүснэгт №14. Төсөл хэрэгжих талбайн ашиглалтын төлөв байдал /2026 оны байдлаар/<br>.....      | 9  |
| Хүснэгт №15. Уурхайн үйл ажиллагаагаар эвдэгдэх газрын хэмжээ .....                           | 9  |
| Хүснэгт №16. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....                        | 12 |
| Хүснэгт №17. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....                                               | 15 |
| Хүснэгт №18. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....                                     | 17 |
| Хүснэгт №19. Хог, хаягдаын менежментийн төлөвлөгөө .....                                      | 20 |
| Хүснэгт №20. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ..              | 21 |
| Хүснэгт № 21. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....                                        | 22 |
| Хүснэгт № 22. БОМТ-ний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх<br>хуваарь ..... | 26 |

## ХАВСРАЛТ ЗУРАГНУУД

|                                                                       |    |
|-----------------------------------------------------------------------|----|
| Зураг №1. Төслийн талбайн байршлын зураг /Google earth/.....          | 1  |
| Зураг № 2. Дүйцүүлэн хамгааллаар нөхөн сэргээх талбайн байдал .....   | 16 |
| Зураг № 3. Хөрс, ургамлын мониторингийн цэгүүдийн байршлын зураг..... | 25 |

## ХАВСРАЛТУУД

1. ААН-ийн гэрчилгээний хуулбар
2. MV-021082 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар
3. ЭБМЗ-ийн дүгнэлт, тушаалын хуулбар
4. ТЭЗҮ-ийн дүгнэлт, тушаалын хуулбар
5. Байгаль орчны лавлагаа
6. Барьцаа төлбөрийн баримтын хуулбар
7. Уулын ажлын төлөвлөгөөний нүүр, маягтууд


## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

|                             |                                                                                                                                                                                                                                                                                                                |
|-----------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Төслийн нэр:                | “Сөрт” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл                                                                                                                                                                                                                                                              |
| Төсөл хэрэгжүүлэгч:         | Хувийн хөрөнгө оруулалттай “Галт үнэг” ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011164096, Регистрийн дугаар: 5254469, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021082, Гүйцэтгэх захирал: А.Батсүрэн                                                                                         |
| Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: | Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 19-р хороо, Туул гол, 48а байр 31 тоот, Утас: 99075193                                                                                                                                                                                                                       |
| Төслийн байршил:            | “Сөрт” нэртэй алтны шороон орд нь Засаг захиргааны нэгжийн хувьд Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт харъяалагдана. Төслийн талбай нь Улаанбаатар хотоос баруун зүгт 465 км-т, Өвөрхангай аймгийн төвөөс баруун хойш 35 км, Тарагт сумын төвөөс зүүн зүгт 7 км зайд 309.32 га талбайг хамран байрлаж байна. |

#### Хүснэгт №1. Тусгай зөвшөөрлийн талбайн солбилцол

| Цэгийн дугаар | Уртраг |     |       | Өргөрөг |     |       | UTM         |            |
|---------------|--------|-----|-------|---------|-----|-------|-------------|------------|
|               | град   | мин | сек   | град    | мин | сек   | X           | Y          |
| 1             | 102    | 31  | 29.27 | 46      | 19  | 11.62 | 5132568.539 | 309449.491 |
| 2             | 102    | 31  | 29.27 | 46      | 17  | 35.86 | 5129613.060 | 309357.117 |
| 3             | 102    | 30  | 40.68 | 46      | 17  | 35.86 | 5129645.633 | 308317.574 |
| 4             | 102    | 30  | 40.68 | 46      | 18  | 04.07 | 5130516.288 | 308344.931 |
| 5             | 102    | 30  | 09.79 | 46      | 18  | 04.07 | 5130537.087 | 307684.160 |
| 6             | 102    | 30  | 09.79 | 46      | 19  | 11.24 | 5132610.181 | 307749.539 |
| 7             | 102    | 30  | 33.51 | 46      | 19  | 11.24 | 5132594.203 | 308256.763 |
| 8             | 102    | 30  | 33.51 | 46      | 18  | 07.21 | 5130618.020 | 308194.605 |
| 9             | 102    | 31  | 05.33 | 46      | 18  | 07.21 | 5130596.652 | 308875.259 |
| 10            | 102    | 31  | 05.33 | 46      | 19  | 11.62 | 5132584.564 | 308937.564 |



Зураг №1. Төслийн талбайн байршлын зураг /Google earth/

## 1.2. Ордын нөөц

Анх ашигт малтмалын ашиглалтын MV-021082 тоот тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын КХ-ээс “Галт үнэг” ХХК -д 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдөр олгосон болно.

“Галт үнэг ХХК нь 2017 онд өөрийн хөрөнгөөр “Сөрт” -ын 2136.11 гектар талбайд шурф малталтын ажлаар хайгуул хийж, шурф нэвтрэлтийн ажлын үр дүнг баталгаажуулан, алтны шороон ордын нөөцийг тогтоосон байна.

### Хүснэгт №2. “Сөрт” алтны шороон ордын нөөцийн нэгдсэн тооцоо

| Блокийн дугаар | Зузаан, м |          | Дундаж агуулга, мг/м³ | Блокын талбай, мян.м² | Эзэлхүүн, м³ |          | Металлын нөөц, кг |        |
|----------------|-----------|----------|-----------------------|-----------------------|--------------|----------|-------------------|--------|
|                | Хучаас    | Давхарга |                       |                       | Хучаас       | Давхарга | Шлих              | Цэвэр  |
| Сорьц-864      |           |          |                       |                       |              |          |                   |        |
| "Жалга-1"      |           |          |                       |                       |              |          |                   |        |
| В-1            | 1.85      | 0.40     | 393                   | 7041.55               | 13.03        | 2.82     | 1.107             | 0.956  |
| В-2            | 1.72      | 0.80     | 233                   | 6525.69               | 11.26        | 5.22     | 1.215             | 1.05   |
| В-3            | 1.30      | 1.07     | 183                   | 3854.22               | 5.01         | 4.11     | 0.751             | 0.649  |
| В-5            | 2.10      | 0.67     | 545                   | 6395.21               | 13.43        | 4.26     | 2.325             | 2.008  |
| В-7            | 1.64      | 0.56     | 384                   | 7561.45               | 12.40        | 4.23     | 1.624             | 1.403  |
| В-8            | 1.85      | 0.60     | 407                   | 10102.04              | 18.69        | 6.06     | 2.467             | 2.131  |
| С-1            | 1.90      | 0.40     | 511                   | 3251.74               | 6.18         | 1.30     | 0.665             | 0.574  |
| С-3            | 1.30      | 0.80     | 307                   | 2942.22               | 3.82         | 2.35     | 0.723             | 0.625  |
| С-4a           | 1.40      | 0.40     | 571                   | 4691.62               | 6.57         | 1.88     | 1.072             | 0.926  |
| С-4b           | 2.53      | 0.67     | 276                   | 4578.17               | 11.58        | 3.05     | 0.841             | 0.727  |
| Бүгд           | 1.79      | 0.62     | 362                   | 56943.91              | 101.97       | 35.29    | 12.79             | 11.04  |
| В- зэрэглэл    | 1.78      | 0.64     | 355                   | 41480.16              | 73.81        | 26.71    | 9.49              | 8.19   |
| С- зэрэглэл    | 1.82      | 0.55     | 385                   | 15463.75              | 28.15        | 8.58     | 3.30              | 2.85   |
| "Жалга-2"      |           |          |                       |                       |              |          |                   |        |
| В-9            | 0.8       | 0.533    | 260                   | 69310.20              | 5.55         | 3.701    | 0.963             | 0.778  |
| В-10           | 0.7       | 0.533    | 134                   | 6598.57               | 4.399        | 3.519    | 0.472             | 0.381  |
| В-11           | 1.2       | 1.0      | 120                   | 7786.05               | 9.343        | 7.786    | 0.933             | 0.754  |
| В-12           | 1.0       | 0.8      | 274                   | 15725.91              | 16.315       | 12.58    | 3.442             | 2.781  |
| В-13a          | 1.1       | 0.64     | 300                   | 13549.27              | 14.904       | 8.13     | 2.439             | 1.971  |
| В-13b          | 1.1       | 0.84     | 292                   | 14139.18              | 14.988       | 11.877   | 3.472             | 2.805  |
| В-14a          | 1.5       | 0.8      | 259                   | 12004.47              | 14.607       | 9.604    | 2.492             | 2.014  |
| В-14b          | 1.0       | 1.08     | 250                   | 15454.85              | 15.455       | 16.691   | 4.173             | 3.372  |
| В-15           | 1.6       | 1.05     | 363                   | 20653.06              | 32.529       | 21.686   | 7.862             | 6.352  |
| В-16           | 1.6       | 1.03     | 268                   | 12687.52              | 20.481       | 13.05    | 3.502             | 3.72   |
| С-2            | 1.2       | 0.4      | 525                   | 2026.01               | 2.431        | 0.81     | 0.425             | 0.343  |
| Бүгд           | 1.18      | 0.858    | 276                   | 127563.75             | 151.003      | 109.434  | 30.175            | 25.271 |
| В - зэрэглэл   | 1.15      | 0.831    | 274                   | 125537.74             | 148.572      | 108.624  | 29.750            | 24.928 |
| С- зэрэглэл    | 1.20      | 0.4      | 525                   | 2026.010              | 2.431        | 0.810    | 0.425             | 0.343  |
| Нийт           | 1.5       | 0.7      |                       | 184507.66             | 252.971      | 144.724  | 42.965            | 36.320 |

## 1.3. 2026 оны ил уурхайн төлөвлөлт

### 1.3.1. Уулын ажлын одоогийн байдал

2023-2024 онуудад Жалга-1 хэсгийн В-8, В-7, С-4а, С-4б, Жалга-2 хэсгийн В-16, В-15, В-14а, В-13а, В-11, В-10 хэсэглэлүүдэд олборлолт болон угаан баяжуулах үйл ажиллагаа явуулсан.

2026 онд бэлтгэл ажил бүрэн хангагдсан учир өөрийн бүрэн хүчин чадлаар үйлдвэрлэлийн ажлыг явуулж Жалга-1 хэсгийн В-1, В-2, В-3, В-5, С-1, С-3 хэсэглэлүүдэд, Жалга-2 хэсгийн В-9, С-2 хэсэглэлүүдийг бүрэн олборлохоор төлөвлөөд байна.

### 1.3.2. Ашиглалтын технологи, горим

Ордын “Жалга-2”-ийн В-9 блокоос эхлэн хөрс хуулалтын ажлыг эхлүүлэхээр тооцоолж байгаа ба элс олборлолт болон баяжуулалтын ажил хөрс хуулж эхэлснээс 5 хоногийн дараачаас эхлэн явагдана. Мөн В-9-р блокийг олборлох явцдаа дотоод овоолго хийхэд боломжтой болно.

Олборлолт эхлэх хэсэгт элс угаах төхөөрөмж, түүнийг тэжээгч утгуурт ачигч болон бусад тоног төхөөрөмжүүдийн үйл ажиллагааг тасралтгүй хангах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс хөрсийг хуулсан байх шаардлагатай. Энэ шаардлагыг хангахын тулд хөрс хуулалтын ажлыг элс олборлож, угааж эхлэхээс өмнө эхлүүлэхээр төлөвлөж байна.

Ордыг нээхдээ В-9 блокоос эхэлж нээх ба шимт хөрсийг карьерийн гадна тал уруу бульдозероор түрж, хөрсийг хуулан түр овоолго байгуулан нээгч налуу траншейг байгуулна. Нээгч траншейн эзлэхүүнийг доорх байдлаар тооцлоо.

Ил уурхайн нээлтийн хувьд ордын хүдэрийн биетүүдийг нам талаас нь траншейг нэвтрээд хөрс, хүдэрийн доголдуудыг нээх ба ашиглалтын үеийн доголын өндөр хөрс ба элсний зузаанаас хамаарч хөрсөнд 1.5 м, элсэнд 0.74 м байна.

#### Хүснэгт №3. Уулын ажлын механикжуулалтын бүтэц

| Ажил                         | Пронессууд (тоног төхөөрөмж) |                   |                 |
|------------------------------|------------------------------|-------------------|-----------------|
| Шимт хөрс хуулалт            | Ухаж түрэх                   | Шимт хөрс хуулалт | Ухаж түрэх      |
|                              | Бульдозер                    | Утгуурт ачигч     | Автосамосвал    |
| Хөрс хуулалт                 | Ухаж түрэх                   | Овоолох           |                 |
|                              | Бульдозер                    | Бульдозер         |                 |
| Элс олборлолт, боловсруулалт | Ачих                         | Тээвэрлэлт        | Алт ялган авах  |
|                              | Экскаватор                   | Автосамосвал      | Угаах төхөөрөмж |

### 1.3.3. Ил уурхайн гүн, хүрээ хязгаар

#### Ил уурхайн гүн

“Сөрт” алтны шороон ордын ил уурхайн гүн нь хөрс болон элсний зузаан, улны бохирдлын зузааны нийлбэрээр илэрхийлэгдэх бөгөөд тус ордын хувьд уурхайн хамгийн бага гүн нь нөөцийн В-3 хэсэгшилд 1.30 м, харин хамгийн их гүн нь нөөцийн С-4в хэсэгшилд 2.53 м байхаар тооцоо гарсан.

#### Ил уурхайн хүрээ, хязгаар

Орд нь хэдийгээр III бүлгийн ордод хамаарч буй боловч ЭБМЗ-ийн хуралдаанаас 2018 оны 03-р сарын 21 өдөр гаргасан ХХ-02-12 тоот нөөцийн дүгнэлтийн 11-д ордын бодитой болон боломжтой нөөцөд тулгуурлан уг ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах боломжтой гэж заасны дагуу С-1, С-2, С-4а, С-4б болон 13-С нөөцийн хэсэгшлүүдийг уурхайн үйлдвэрлэлийн нөөцөд хамааруулан тооцоолсон.

Уурхайн хүрээ хязгаар нь ордын нөөц бодсон талбайн хэмжээнд тодорхойлогдох бөгөөд уг ордын хувьд хайгуулын ажлын үр дүнгээр тооцогдож Улсын нөөцийн нэгдсэн санд бүртгэгдсэн нөөцийг бүрэн хэмжээнд олборлох бүрэн боломжтой юм.

Уурхайн хөрс хуулалтын ажлыг бульдозероор гүйцэтгэх бөгөөд харин элс олборлолтыг экскаватор автосамосвалын хослолоор гүйцэтгэнэ. Иймд уурхайн доголын нүүрний өнцөг нь болон доголын өндөр дараах хэмжээстэй байна гэж үзсэн. Үүнд:

- Хөрс хуулалтын доголын өндөр (Хучаас хөрс - 0.1) м;
- Хөрсний доголын нүүрний өнцөг бульдозерийн түрэх хэм 9 град
- Элсний доголын өндөр (Элсний зузаан + 0.2) м 70 град
- Элсний доголын нүүрний өнцөг

### 1.3.4. Ил уурхайн хүчин чадал, уулын ажлын горим

Хүснэгт №4. Ил уурхайн 2026 оны нийт уулын ажлын хэмжээ

| № | Үзүүлэлт              | Нэгж   | Хэмжээ |
|---|-----------------------|--------|--------|
| 1 | Уулын цул             | мян.м³ | 97.26  |
| 2 | Элсний хэмжээ         | мян.м³ | 29.38  |
| 3 | Хөрс хуулалтын хэмжээ | мян.м³ | 58.36  |
| 4 | Шимт хөрс             | мян.м³ | 9.52   |

### 1.3.5. Ил уурхайн элс олборлолтын хүчин чадал

Орд нь тогтцын хувьд зүүн хойноос урагшаа сунаж тогтсон, 0-3 градусын хэвтээ уналтай бөгөөд алт агуулсан давхаргын хувьд ямар нэгэн цэвдэгшил болон усны хүндрэл байхгүй юм.

2026 онд төлөвлөж буй ил уурхайн хүрэн дэх нийт хуулах хөрсний хэмжээ нь 67.88 мян.м³, олборлох элсний хэмжээ нь 29.38 мян.м³ байхаар тооцоо гарсан. Орд байрлаж буй Өвөрхангай аймгийн Тарагт сумын хэсэг нь үйлдвэрлэлд ашиглах гадаргын устай бөгөөд газрын гүний усыг их хэмжээгээр авч ашиглахад хязгаарлагдмал юм. Учир нь уг талбайд гаргасан 2 ширхэг худгийн нийт ундарга нь 11.6 л/с байгаа бөгөөд бид энэхүү усны эх үүсвэр болон тухайн ордын дэргэдэх карьерын шүүрлийн усыг насосоор соруулан цэвэр усны нуурт сэлбэх боломжтой юм. Иймд нийт усны эх үүсвэр, уурхайн жилд ажиллах хоног, хоногт ажиллах цаг, эргэлтийн усны хэмжээ гэх мэт үзүүлэлтээс шалтгаалан уурхайн элс олборлолтын хүчин чадлыг жилд 100 мян.м³ элс угаан баяжуулахаар төлөвлөсөн. Харин уурхайн хөрс хуулалтын хэмжээ нь тухайн жилд олборлолтонд өртөх нөөцийн хэсэгшил дэх хөрсний зузаанаас хамааран өөр өөр байна.

### 1.3.6. Уурхайн ажлын горим

Уурхайн бэлтгэл үйл ажиллагаа 04-р сарын 20-аас уурхайн талбайд эхэлэх бөгөөд эхний ээлжинд уурхайн талбайд угаах төхөөрөмж байрлуулах, уурхайн тосгон байгуулах, худгуудын холболт хийх, усан сангуудыг байгуулах, техникийн бэлэн байдлыг хангах зэрэг ажил хийгдэх бөгөөд үүнд нийт 15 хоногийг зарцуулна. Уурхайн хөрс хуулалтын ажил 05-р сарын 05-ээс эхлэн хийгдэж эхэлэх бөгөөд элсийг ухаж ачих ажил хийх боломжтой хэмжээний талбай бэлэн болох хугацаа буюу эксковаторын ажлын бүтээмжээр 2 хоногийг дараагаас элс олборлолтын ажил эхэлсэн бөгөөд элс угаах ажил элс олборлох ажлыг дагалдан 2 хоногийн дараагаас эхэлсэн болно. Тухайн бүс нутаг нь говь хээрийн бүсэд хамаарах тул намартаа дулаан тогтуун байдаг бөгөөд орд орчимд ажиллаж буй алтны уурхайнууд нь 11 сарын эхэн хүртэл ажилладаг бөгөөд бид уурхайн ажлыг 10-р сарын 20-нд баяжуулалтын ажил зогссож нөхөн сэргээлтийн ажил 11 –р сарын 05 хүртэл үргэлжлүүлэн хийгдэх болно.

Уурхай нь хоногт хоёр ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг ажилласан ба шлюз авах, ээлж солилцох, хоолонд орох хугацааны нийлбэр нь 2 цаг байна. Монгол Улсын “Хөдөлмөрийн хууль”-нд заасны дагуу жилд амрах баяр, ёслолын хоног, цаг агаарын хүндрэлээс шалтгаалан ил уурхайн ажиллагаа сул зогсож болзошгүй хугацааг тооцоход уурхай нь жилдээ 153 хоног ажилласан бөгөөд үүнд уурхайн хавар бүр ажил эхлэхийн өмнө хийгдэх бэлтгэл ажлын хугацаа багтсан болно.

Хүснэгт №5. Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа

| № | Үзүүлэлт                                 | Х.н   | хэмжээ |
|---|------------------------------------------|-------|--------|
| 1 | Жилийн ажиллах хуанлийн өдөр             | хоног | 153    |
| 2 | Баяр ёслолын үеийн амралтын өдөр         | хоног | 6      |
| 3 | Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засвар | хоног | 6      |

|    |                                           |       |     |
|----|-------------------------------------------|-------|-----|
| 4  | Цаг агаарын саатал                        | хоног | 6   |
| 5  | Уурхайн ажиллах хоног                     | хоног | 141 |
| 6  | Ажил эхлэхийн өмнөх бэлтгэл ажил          | хоног | 5   |
| 7  | Хөрс хуулалтын ажлын хоног                | хоног | 130 |
| 8  | Элс олборлолтын ажлын хоног               | хоног | 136 |
| 9  | Элс угаах ажлын хоног                     | хоног | 136 |
| 10 | Хоногт ажиллах ээлжийн тоо                |       | 2   |
| 11 | Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа             | цаг   | 10  |
| 12 | Ээлж солилцох, шлюз авах, хооллох хугацаа | цаг   | 2   |

### 1.3.7. Уулын ажлын өрнөл дараалал

**2026 онд:** Уурхайн нээлтийг ордын хамгийн хойд хэсгийн Жалга-2 хэсгийн В-9, блокоос эхлэн эксковаторын үргэлжилсэн гарцаар нээхээр төлөвлөсөн. Учир нь ордын хойд хэсэгтээ элсэн дэх алтны дундаж агуулга өмнөд хэсгээ бодвол өндөр юм. Ухаж ачихад бэлтгэгдсэн нөөцийн гадаргын талбайн хэмжээ нь хэсэгшлийн уртын дагуу 200 м харин өргөн нь хэсэгшлийн өргөнтэй тэнцүү байсан. 2026 онд уулын ажил Жалга-1 хэсгийн В-1, В-2, В-3, В-5, С-1, С-3 хэсэглэлүүдэд, Жалга-2 хэсгийн В-9, С-2 хэсэглэлүүдийг бүхэлд нь олборлох тооцоо гарсан. 2026 онд нийт 67.88 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 208 мг/м<sup>3</sup> дундаж агуулгатай 29.38 мян.м<sup>3</sup> элс олборлохоор төлөвлөөд байна.

#### Хүснэгт №6. 2026 оны уулын ажлын төлөвлөгөө

| № | Блокийн дугаар                                                         | Уулын цул, м <sup>3</sup> |              | Дундаж<br>агуулга мг/м <sup>3</sup> | Металл, кг  |             |
|---|------------------------------------------------------------------------|---------------------------|--------------|-------------------------------------|-------------|-------------|
|   |                                                                        | Хөрс                      | Элс          |                                     | Шлих        | Х.Цэвэр     |
| 1 | Жалга-1 хэсгийн В-1, В-2, В-3, В-5, С-1, С-3, Жалга-2 хэсгийн В-9, С-2 | 67.88                     | 29.38        | 201                                 | 6.84        | 5.91        |
|   | <b>Нийт</b>                                                            | <b>67.88</b>              | <b>29.38</b> | <b>201</b>                          | <b>6.84</b> | <b>5.91</b> |

### 1.3.8. Хөрс хуулалтын технологи

Хөрс хуулалтын ажил нь үржил шимт хөрсийг урьдчилан хуулах ба үндсэн хучаас хөрсийг хуулах гэсэн үндсэн 2 шатлалтай явагдана.

**Нэгдүгээр үе шат.** Уурхайн уулын ажлын ахилт, өрнөлтэй уялдуулан тухайн жилд ашиглалтанд өртөх талбайн болон нээлтийн хэсгийн хөрсний гадаад овоолгод дарагдах талбайн өнгөн хөрсийг уг бүс нутгийн хөрсний шимт болон шилжилтийн үеийн зузаанаас хамааруулан 0.1-0.3 хүртэлх зузаантайгаар хуулах бөгөөд уурхайн эцсийн хүрээний гадна талд салхины шууд нөлөөллөөс далд нөмөр газар овоолго үүсгэн хураана.

“Сөрт” алтны уурхайн хувьд говь хээрийн бүсэд хамаарах бөгөөд уг талбайд хийгдсэн газрын төлөв байдлын суурь судалгааны тайлангаас үзэхэд шимт болон шимэрхэг хөрсний үеийн зузаан дундажаар 0.2 м байна. Иймд шимт хөрсийг 0.2 м зузаантайгаар хуулна. Мөн үүнээс гадна үйлдвэрлэлийн зориулалтаар уурхайн болон зам талбай барилга байгууламж, угаах төхөөрөмж, элсний түр овоолго зэрэгт өртөн эвдэгдэх талбайнуудын үржил шимт хөрсийг 0.2 м зузаантайгаар урьдчилан хуулж хадгална. Тусгайлан хадгалсан үржил шимт хөрсийг уурхайн үйл ажиллагааны явцад болон үйл ажиллагаа дууссаны дараагаар уг эвдэгдсэн талбайд нөхөн сэргээлтийн ажил хийхэд ашиглана. Шимт хөрсний овоолгын өндөр нь 5м-ээс өндөр байж болохгүй.

**Хоёрдугаар үе шат.** “Сөрт” алтны шороон ордын хувьд хучаас хөрсний хэмжээ харьцангуй нимгэн тул бульдозероор хуулахаар төлөвлөсөн бөгөөд уурхайд ашиглагдсан хоосон орон зайг бий болгож хөрсийг бульдозерын гадаад овоолгод хураасан бөгөөд ашиглагдсан орон зай бий болсны дараагаар бульдозерын дотоод овоолгод байршуулна. Бульдозерын гадаад овоолго байгуулах үед хөрс хуулалтын доголын хажуугийн өнцөг 8-9

градус байна. Харин ашиглагдсан хоосон орон зай руу ордын суналын дагуу түрэлт хийх бөгөөд нөөцийн хэсэгшлийг түүний өргөнөөс хамааруулан 2-3 хувааж хөрс хуулалтын ажлыг явуулна. Бульдозерын түрэлтийн ажлын паспортыг доор үзүүлэв.

### 1.3.9. Олборлолтын технологи

В-14b блокийн алт агуулсан элсний дундаж зузаан нь 1.08 м байгаа бөгөөд ул таазны бохирдлыг оруулаад 1.28 м орчим болсон. Ордын алт агуулсан давхаргыг экскаватор автосамосвалын хослолоор ухаж тээвэрлэнэ гэж тооцсон. Олборлолтын доголын өндөр нь элсний зузаан болон ул таазны бохирдолын зузаантай нийлбэртэй тэнцүү байна. Харин олборлолтын доголын налуугийн өнцөг нь элсний давхараасын зузаанаас 60-70 градус байна. Хөрс нь хуулагдсан талбайд 40-50 м урт фронтын дагуу ухаж ачих ажлыг гүйцэтгэх бөгөөд элс олборлолтонд ажиллах экскаваторын үзүүлэлтээс хамааран 8-10 м орлоор ажиллана.

#### Ашиглалтын системийн элементүүд

|                           |                                    |
|---------------------------|------------------------------------|
| Олборлолтын доголын өндөр | Элсний зузаан+ хамгаалалтын цамц м |
| Хөрсний доголын өндөр     | Хөрсний зузаан - таазны бохирдол м |
| Орлын өргөн               | 8-10 м                             |
| Автозамын өргөн           | 8.5 м                              |
| Олборлолтын фронтын урт   | 40-50 м                            |

### 1.3.10. Уулын ажлын процессууд

#### Хөрсний хуулалтын процесс

Уурхайн хөрс хуулалтын ажлыг бульдозер болон экскаваторын хослолоор гүйцэтгэхээр төлөвлөсөн. Эхлээд уурхайн тухайн жилд олборлолтонд өртөх талбайн шимт хөрсийг 0.2 м зузаантайгаар бульдозероор хуулж утгуурт ачигч автосамосвалын хослолоор ачиж тээвэрлэн уурхайн хүрээний гадна 5 м -ээс өндөргүйгээр хураана. 2026 онд хуулсан нийт шимт хөрсний хэмжээ нь 8.30 мян.м<sup>3</sup> байсан.

Уурхайн нийт хучаас хөрсний хэмжээ нь 67.88 мян.м<sup>3</sup> байгаа бөгөөд хөрс хуулалтын ажил жилд 125 хоног үргэлжлэхээр төлөвлөсөн. Төсөл хэрэгжүүлэгчийн худалдан авахаар төлөвлөсөн XGMA TY160 маркийн 163.2 м.х хөдөлгүүрийн чадалтай бульдозерыг ашиглахаар сонгосон.

“Сөрт” алтны шороон ордын хөрс хуулах ажилд XGMA TY160 маркийн бульдозер 1 ширхэг байхад хангалттай байна.

#### Элс олборлолтын процесс

Алт агуулсан элсийг экскаваторын тусламжтайгаар мөргөцгөөс шууд ухаж ачихаар тооцсон. Ордын нийт элсний хэмжээ 29.38 мян.м<sup>3</sup> байх бөгөөд уурхайн технологийн усны эх үүсвэр болон хэрэглээнээс хамааран жилд 100.0 мян.м<sup>3</sup> элс олборлохоор тооцсон. Элс олборлолтын ажилд төсөл хэрэгжүүлэгчид ашиглахад бэлэн байгаа Hyundai R450LC маркийн 1.2 м<sup>3</sup> утгуурын багтаамж бүхий экскаваторыг ажиллуулахаар сонгосон байна.

#### Эфел галь ачих процесс

Угаах төхөөрөмжөөс гарах эфель болон гаалийг 3 м<sup>3</sup> утгуурын багтаамж бүхий LUIGONG маркийн утгуурт ачигчаар автосамосвалд ачихаар төлөвлөсөн.

### Элс тээвэрлэх процесс

Алт агуулсан элсийг мөргөцгөөс угаах төхөөрөмж хүртэл автосамосвалаар тээвэрлэх бөгөөд элс тээвэрт төсөл хэрэгжүүлэгчид бэлэн байгаа Howo маркийн 16 м<sup>3</sup> тэвшний багтаамж бүхий автосамосвалыг ажиллуулахаар төлөвлөсөн байна.

#### 1.3.11. Овоолгын процесс

### 1.4. Баяжуулалтын технологи

#### Баяжуулалтын технологи

Ил уурхайгаас олборлосон алт агуулсан элсийг авто тээврээр тээвэрлэн угаан баяжуулах төхөөрөмжийн дэргэдэх талбайд авч ирэх бөгөөд утгуурт ачигчийн тусламжтайгаар угаан баяжуулах төхөөрөмжийн хүлээн авах бункерт тэжээнэ. Алт агуулсан элсийг цагт 40 м<sup>3</sup> хүчин чадал бүхий скруббер, шлюзийн хослол бүхий багц тоног төхөөрөмжөөр угаан баяжуулна.

#### “Сөрт” ордын бүтээгдэхүүн гаргалтын тооцоо

Хүснэгт №7. “Сөрт” ордын элс олборлолт /2026 он/

| № | Ашиглалтын жил | Элс          | Дундаж агуулга мг/м <sup>3</sup> | Металл, кг  |             |
|---|----------------|--------------|----------------------------------|-------------|-------------|
|   |                |              |                                  | Шлих        | Х.цэвэр     |
| 1 | 2026 он        | 29.38        | 234                              | 7.99        | 6.90        |
|   | <b>Нийт</b>    | <b>29.38</b> | <b>234</b>                       | <b>7.99</b> | <b>6.90</b> |

Хүснэгт №8. Элс угаалт бүтээгдэхүүн гаргалт /2026 он/

| № | Ашиглалтын жил | Элс          | Дундаж агуулга мг/м <sup>3</sup> | Металл авалт % |             |
|---|----------------|--------------|----------------------------------|----------------|-------------|
|   |                |              |                                  | Шлих           | Х.цэвэр     |
| 1 | 2026 он        | 29.38        | 201                              | 6.84           | 5.91        |
|   | <b>Нийт</b>    | <b>29.38</b> | <b>201</b>                       | <b>6.84</b>    | <b>5.91</b> |

#### Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж

Хүснэгт №9. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн сонголт

| Тоног төхөөрөмжийн нэр             | Марк             | Зориулалт                                                             | Тоо ширхэг |
|------------------------------------|------------------|-----------------------------------------------------------------------|------------|
| Хүлээн авах бункер                 | 6 м <sup>3</sup> | Анхдагч элс хүлээн авах                                               | 1          |
| Скрubber, м <sup>3</sup> /цаг      | 40               | Алт агуулсан элсийг угаан ангилах                                     | 1          |
| Баяжуулах ширээ, м <sup>3</sup> /ц | 2.0              | Шлюзийн баяжмалыг гүйцээн баяжуулах                                   | 1          |
| Эргэлтийн усны насос               | 12               | Тунах нуурнаас эргэлтийн ус шахах                                     | 1          |
| Цэвэр усны насос                   | 18200*500        | Угаах тоног төхөөрөмжийг технологийн усаар хангах                     | 1          |
| Гүйцээн баяжуулах багц, хэрэгслүүд | -                | Алт агуулсан элсний баяжмалыг гүйцээн баяжуулжшлихийн алт гаргаж авах | 1          |

### 1.5. Дэд бүтэц

#### Уурхай ба тосгоны цахилгаан хангамж:

Уурхайн нь дизель хөдөлгүүрээр цахилгаан хангамжаа шийдэх болно.

#### Уурхайн усан хангамж:

##### 1) Усан хангамжийн эх үүсвэр

Төсөл хэрэгжүүлэгч нь унд ахуй болон технологийн хэрэгцээний усыг өөрийн эзэмшлийн 2 ширхэг гүний худаг болон карьерийн шүүрлийн усаар хангах бөгөөд ордоос ойролцоогоор 2-3 км-т /худаг/ байрлана.

*Хүснэгт №10. Унд ахуйн болон технологийн усыг хангах гүний худгийн мэдээлэл*

| №            | Худгийн нэр | Ундарга,<br>л/сек | Солбицол                      | Гүн, м | № |
|--------------|-------------|-------------------|-------------------------------|--------|---|
| 1            | Худаг-1     | 8.0               | 46°19'22.20"<br>102°30'31.43" | 60.0   | 1 |
| 2            | Худаг-2     | 8.0               | 46°19'22.22"<br>102°30'31.21" | 60.0   | 2 |
| Нийт ундарга |             | 16.0              | -                             |        |   |

*2) Ус хэрэглээний тооцоо*

Усны хэрэглээний тооцоог БОНХАЖ -ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаал “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм” -д тусгасан нормын дагуу гүйцэтгэсэн.

Алт олборлож байгаа үйлдвэрүүдийн туршлага, түүнчлэн “Сөрт” алтны шороон ордын элс баяжуулах технологийн тооцоог баримталж шаардагдах усны 30%-ийг цэвэр усаар сэлбэх ба 70%-ийг технологийн эргэлтийн усаар хангах юм. Ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай учир 1 м.куб элс угаахад 4.0 м³ ус хэрэглэхээр тооцоолов.

Баяжуулах төхөөрөмжийн хаягдлыг эргэлтийн усан санд урсган хуримтлуулж, тунасан усыг эргүүлж, технологид ашиглана. Тухайн орон нутгийн цаг агаарын байдлаас шалтгаалан усан сангийн усанд ууршилт болон шүүрлээс шалтгаалан алдагдал гардаг. Усан санд хуримтлуулсан усны шүүрэлтийг хязгаарлах зорилгоор усан санг зориулалтын нийлэг материалаар доторлохоор төлөвлөж байна. Иймд уг алдагдлыг гадаад эх үүсвэрээс цэвэр усаар нөхөж, нуурын түвшинг тогтмол барьж байх шаардлагатай.

*Хүснэгт №11. Жилд шаарддагатай технологийн усны нийт хэрэглээ*

| № | Элсний<br>хэмжээ м³ | 1 м³ элс угаах<br>усны хэмжээ м³ | Нийт усны<br>хэрэглээ м³ | Эргэлтийн ус<br>/70%/ м³ | Цэвэр ус<br>/30%/ м³ |
|---|---------------------|----------------------------------|--------------------------|--------------------------|----------------------|
| 1 | 29,380              | 4                                | 117,520                  | 82,264                   | 35,256               |

*Хүснэгт №12. Хоногт шаардагатай технологийн усны хэрэглээ*

| № | Элсний<br>хэмжээ м³ | Эргэлтийн<br>ус 70% | Цэвэр ус<br>30% | Жилд ажиллах<br>хоног | Эргэлтийн<br>ус м³/хон | Цэвэр ус<br>м³/хон |
|---|---------------------|---------------------|-----------------|-----------------------|------------------------|--------------------|
| 1 | 29,380              | 82,264              | 35,256          | 75                    | 1,096.8                | 470.08             |

**Усан сан.** “Сөрт” алтны шороон ордын байрлаж буй бүс нутаг нь гадаргын ус байхгүй бөгөөд гүний худгаар технологийн усны хэрэгцээг хангана. Иймд усан сангийн байгууламжийг аль болох усны алдагдал бага байлгах зорилгоор зориулалтын нийлэг материалаар доторлохоор төлөвлөсөн. Уурхайн усан сангийн бүтэц нь бидний төлөвлөж буйгаар 2 ширхэг тунаах нуур болон 1 ширхэг цэвэр усны нууртай байна.

*Хүснэгт №13. Технологийн усан сангийн багтаамж*

| №           | Нуурын эзэлхүүн м³ |                |                 |
|-------------|--------------------|----------------|-----------------|
|             | Тунаах нуур -1     | Тунаах нуур -2 | Цэвэр усны нуур |
| 1           | 5,200              | 4,500          | 2,400           |
| <b>Нийт</b> | <b>12,100</b>      |                |                 |

## 2. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

### Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

“Сөрт” нэртэй орд нь Засаг захиргааны нэгжийн хувьд Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт харъяалагдах ба Улаанбаатар хотоос баруун зүгт 465 км-т, Өвөрхангай аймгийн төвөөс 35 км, Тарагт сумын төвөөс зүүн зүгт 7 км зайд байр зүйн зургийн L-48-62-A, L-48-61-B нэрлэбэрт байрлана. Улаанбаатар хот, Өвөрхангай аймаг болон баруун бүсийг холбосон сайжруулсан авто зам тус ордын талбайгаас урагш 25 км-т өнгөрдөг байна.

“Сөрт” нэртэй MV-021082 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл нь нийт 309.32 га талбайг хамран байрлаж байна.

#### Хүснэгт №14. Төсөл хэрэгжих талбайн ашиглалтын төлөв байдал /2026 оны байдлаар/

| №  | Үзүүлэлт                       | Төлөв байдал                                  | Талбай, га    |
|----|--------------------------------|-----------------------------------------------|---------------|
| 1  | Элэгдэл эвдрэлд өртөөгүй газар | Бага зэргийн сөөгөрхөг, дунд зэргийн чулуутай | 200.00        |
| 2  |                                | Бага зэргийн чулуурхаг                        | 109.32        |
| 3  | Ухсан нүх                      | Хөрс, ургамалгүй                              | 1.06          |
| 4  | Овоолго                        | Хөрс, ургамалгүй                              | 6.24          |
| 5  | Кемп Оффис                     | Талхлагдсан                                   | 0.24          |
| 6  | Авто засвар                    | Талхлагдсан                                   | 0.30          |
| 7  | Зогсоол                        | Талхлагдсан                                   | 0.03          |
| 8  | Хогийн цэг                     | Физик бохирдолтой                             | 0.01          |
| 9  | Өөрчлөлт орсон талбай          | Талхлагдсан, ухагдсан                         | 5.40          |
| 10 | Карьер                         | Хөрс, ургамалгүй                              | 6.15          |
|    | <b>Дүн</b>                     |                                               | <b>309.32</b> |

Төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан газар нутаг, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байхгүй байна.

### Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Ашиглалтын эхний жилийн хугацаанд нийтдээ “Жалга-1”-ны ордын хувьд ил уурхайн олборлолтонд 4.15 га, гадаад овоолгод дарагдах 0.55 га. угаах төхөөрөмж болон эфель гаалийн түр овоолго, усан сан түүний зам зэрэгт эвдрэлд өртөх талбай 1.47 бөгөөд нийт 6.17 га талбай, “Сөрт”-н ордын хувьд ил уурхайн олборлолтонд өмнөх онуудад өртсөн талбай байхгүй, шинээр эвдрэлд 4.15 га талбай үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хамааран онцгой болон бага зэргийн эвдрэлд өртөнө.

2026 оны хувьд Уурхайн олборлолтонд өртөх 4.15 га, гадаад овоолгод дарагдсан 0.55 га, барилга байгууламжууд баригдсан 0.8 га, угаах төхөөрөмж болон эфель галийн түр овоолго, усан сангийн зориулалтаар эвдрэлд өртөгдсөн талбай 2.24 бөгөөд нийт 7.74 га талбай үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хамааран онцгой болон бага зэргийн эвдрэлд өртөнө. Эдгээр эвдрэлд орсон талбайн үржил шимт хөрсийг тусгайлан 0.15-0.25 м хүртэлх зузаантайгаар хуулж шимт хөрсний овоолгод хадгалахаар тооцсон.

#### Хүснэгт №15. Уурхайн үйл ажиллагаагаар эвдэгдэх газрын хэмжээ

| д/д | Тусгай зөвшөөрлийн дугаар | Уурхайн малталтанд өртөх, га | Гадаад овоолгод дарагдсан | Угаах төхөөрөмж, барилга байгууламжид |
|-----|---------------------------|------------------------------|---------------------------|---------------------------------------|
| 1   | MV-021082                 | 5.24                         | 0.55                      | 3.04                                  |

### **Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Ил уурхайн хөрс хуулалт, тээвэрлэлт, овоолгоос үүсэх тоосжилт, дуу чимээ зэрэг нөлөөллөөс агаарын бохирдол үүснэ.

### **Төслөөс гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Төслийн талбай нь Онги голын ай савд багтах ба төслийн талбайд гол горхи зэрэг гадаргын уст цэг байхгүй байна.

Төслийн талбай нь гидрогеологийн хувьд энгийн нөхцөлтэй хайгуул, алтны олборлолт хийхэд усан хангамжийг шүүрлийн усаар шийдсэн ба Тарагтын хагарлын бүс нь гидрогеологийн нөхцөл муутай, усжилтаар сулхан бүс нутагт хамрагдана.

Ус ашиглалтаас үүсэх нөлөөлөл – технологи, уурхайн унд ахуй, тоосжилт дарах зориулалтаар ус ашиглалтаас газрын доорх усны нөөц болон уст үед бага хэмжээний өөрчлөлт оруулна.

Усны бохирдол – Уурхайн дотоод хяналт сулрах, санаатай болон санамсар болгоомжгүй байдлаар хөрсөнд шатах тослох материал болон хатуу хаягдлууд алдагдах нь хөрсөөр дамжин газрын доорх усыг бохирдуулах эх үүсвэр болж болзошгүй.

### **Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Тус нутагт тархсан уулын хүрэн шороон хөрс нь Монгол орны тал хээр, уулсын хоорондох хөндий өргөрөгийн ба хотгорын бүс, дэд бүсүүд үүсгэж дорнод хэсэгт 600-700 м-ээс өрнөд хэсэг 2400 м хүртэл үнэмлэхүй өндөрт хамгийн түгээмэл тархсан байдаг.

Харин төслийн талбайд делювийн гарал үүсэлтэй хурдас дээр бий болсон, хөнгөн шавранцар болон элсэнцэр цөлөрхөг хээрийн бор хөрс тархсан байна. Гэхдээ тус газрын ашиглалт явуулж байсан болон одоо ашиглаж байгаа газар нь техникийн болон хүний хүчин зүйлийн нөлөөлөлд орсон ухагдаж эвдэрсэн, физик бохирдолтой газар юм.

Хөрсний өнгөн хэсэгт зарим хүнд металлуудын агууламжийг MNS 5850:2008 стандарттай харьцуулахад дээж №1 дээжинд хлор 0.1 мг/кг, кадмий 0.5 мг/кг, мөнгөн ус 0.3 мг/кг, бром 0.8 мг/кг, хром 0.6 мг/кг, кобальт 23.4 мг/кг, стронций 557.0 мг/кг, рубиди 109.7 мг/кг, циркон 0.6 мг/кг, хар тугалга 333.2 мг/кг, цайр 145.0 мг/кг, зэс 26.6 мг/кг агууламжтай, харин никель илэрсэнгүй.

Хар тугалгын агууламж шинжилгээнд хамруулсан бусад хүнд металлуудаас илүү хэмжээтэй байгаа нь шавранцар хөрсний хүлцэх дээд агууламжаас 7.8 мг/кг-аас 10.6 мг/кг-аар их байна. Харин задлан шинжилгээнд хамруулсан бусад хүнд металлуудын хувьд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага юм.

ТЭЗҮ-ийн тодотголд дурдсанаар төсөл хэрэгжих 2 жилийн хугацаанд 55.9 мян.м<sup>3</sup> шимт хөрс хуулж, нийт 21.3 га талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлд оруулахаар байна.

Хөрсөн бүрхэвч нь ил уурхайн хөрс хуулалт, олборлолтыг гүйцэтгэх, тээврийн зам, ашиглах явцад эвдэрч доройтохын зэрэгцээ шатах тослох материал санамсаргүй асгаснаас хөрсийг бохирдуулах эрсдэлтэй.

### **Төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Судалгааны явцад 3 цэг дээр ургамалжилт, төлөв байдлын бичиглэл хийж, ургамалжилтын төрхөөр цөлөрхөг хээрийн ургамалжилтын дараах 2 үндсэн бүлгэмдэлтэй байгааг тогтоов. Үүнд:

- Монгол өвс-таана-бударганат

- Таана-монгол өвст

Ил уурхайн олборлолт, тээвэрлэлт явагдах талбайн ургамлан нөмрөг дээрх үйл ажиллагаануудын нөлөөгөөр устаж доройтох нь зайлшгүй юм. Ургамлан нөмрөг нь олборлолт, тээвэрлэлтийн ажлын шатанд тоос шороо боссоны улмаас доройтно.

**Төслөөс амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Тус нутаг нь хөхтөн амьтны газарзүйн мужлалаар (Банников, 1954)-аар Хойт доод муж, тайгын провинци, Хэнтий, Монгол Дагуурын хээрийн тойргуудад хамаарна. Уурхайн талбайн амьтны аймгийн судалгаагаар 1 зүйлийн шавж, 6 зүйлийн хоёр нутагтан мөлхөгчид, 21 зүйлийн шувуу, 6 зүйлийн хөхтөн, нийт 3 зүйлийн сээр нуруутан амьтдыг бүртгэн тэмдэглэв.

Төслийг хэрэгжүүлэх хугацаанд хүн машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн нэмэгдсэнээс, уурхайн олборлолтын үед үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

**Төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Төслийн талбайд оршин суугчид үгүй учир нутгийн иргэдийн газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөхгүй, нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэхгүй.
- Төсөл хэрэгжсэнээр нутгийн иргэд тодорхой хэмжээнд ажлын байраар хангагдана.
- Хамгийн ойр орших суурин газар нөлөөллийн бүсийн гадна байгаа тул сөрөг нөлөөлөлд өртөхгүй.

Уг төслийг хэрэгжүүлснээр нийт 25 хүний ажлын байр бий болсон бөгөөд нийт улс болон орон нутгийн төсөвт нийт 257.66 сая төгрөг хуримтлуулахаар байна.

Уурхайн ажлын үед машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс ажилчдын эрүүл мэндэд бага зэргийн сөрөг нөлөөтэй.

**Төслөөс түүх соёлын дурсгалт зүйлс, тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Төсөл хэрэгжих газрын ойролцоо түүх соёлын дурсгалт зүйлс илрээгүй бөгөөд илэрсэн тохиолдолд тэр даруйд нь холбогдох төрийн захиргааны төв байгууллагад мэдээллэх үүрэгтэй. Тус төслийн талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.

### 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

#### 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөрс болон ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арилгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн авч үзсэнийг дараах хүснэгтэд бүрэн дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт №16. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| №             | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл                                                                                                                                          | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ                                                                                                                  | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ          | Хэмжих нэгж    | Нэгжийн өртөг                                                                                         | Нийт зардал, мян.төг   | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж                                              | Баримтлах стандарт, аргачлал                                                                            |
|---------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------|----------------|-------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|-----------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|
| Агаарын чанар |                                                                                                                                                                          |                                                                                                                                                                      |                                        |                |                                                                                                       |                        |                                                                             |                                                                                                         |
| 1             | Ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс ялгарах хорт хий хий орчныг бохирдуулах                                                                             | Уурхайн бүх авто тээврийн хэрэгсэл болон өөрөө явагч хэрэгслийн агаарт гаргах хаягдалд ноогдуулах төлбөрийг төлөх                                                    | Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэл | мян.төг        | Бохирдуулагчийн хэмжээгээр төлбөр төлнө                                                               | Үйл ажиллагааны зардал | 2026 оны 07-р сарын 20-ны өдөр                                              | Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 5.4-р зүйл                                                    |
| 2             | Хатуу хучилтгүй зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, бүтээгдэхүүн тээвэрлэж буй машинаас тоосжилт үүсэх                                                              | Усны машин ашиглан тоосжилт үүсэх замуудыг дулааны улиралд услах, чийглэх, замыг дагтаршуулах                                                                        | Шороон замууд                          | м <sup>2</sup> | Өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хэрэгжүүлэх ажил тул үйл ажиллагааны урсгал зардлаар хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | 2026 онд 07-р сараас 09-р сар хүртэл бороотой өдрөөс бусад өдрүүдэд тогтмол | - Агаарын тухай хуулийн 9, 11, 23-р зүйл<br>- NS4585:2016 - Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. |
|               |                                                                                                                                                                          | Тээвэр хийх машины хурдыг хязгаарлаж, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулах                                                         |                                        | ш              | 1,500.00                                                                                              | 1,500.0                | 2026 оны 07-р сарын 20-ны өдөр                                              |                                                                                                         |
| 3             | Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас ууршилтаар органик нэгдлүүд агаарт дэгдэж тухайн орчны агаар болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх | Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах, саармагжуулах хэрэгслийг | Төслийн талбайд байрлах ШТС            |                | ХАБЭА-н зардалд хамаарна                                                                              | Үйл ажиллагааны зардал | 2026 онд үйл ажиллагааны турш өдөр бүр хяналт тавьж ажиллана.               | Өдөр тутмын хяналтаар                                                                                   |

|                                                    |                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                  |                       |    |                                                                     |                |                                                                                                                  |                                                                                                                                     |
|----------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|----|---------------------------------------------------------------------|----------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                    |                                                                                                                                                   | талбайд бэлэн<br>байлгах                                                                                                                                                                                         |                       |    |                                                                     |                |                                                                                                                  |                                                                                                                                     |
| <b>Зардлын дүн</b>                                 |                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                  |                       |    |                                                                     | <b>1,500.0</b> |                                                                                                                  |                                                                                                                                     |
| <b>Гадаргын болон газрын доорх ус</b>              |                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                  |                       |    |                                                                     |                |                                                                                                                  |                                                                                                                                     |
| 4                                                  | Усыг тооцоогүй<br>ашигласнаас газрын доорх<br>усны нөөц хомсдох                                                                                   | Усыг үр ашигтай хэрэглэх<br>талаар ухуулга,<br>сурталчилгааг ажилчдад<br>хийх, мэдээллийн хуудас<br>байрлуулж шинэчилж байх.                                                                                     | Ус ашиглах<br>хэсгүүд |    | 500.0                                                               | 500.0          | 2026 оны 07-р сарын<br>20-нд хэрэгжүүлнэ.                                                                        | Усны тухай хууль                                                                                                                    |
| 5                                                  | Шатах, тослох материал,<br>нефтийн бүтээгдэхүүн зэрэг<br>бодис алдагдах, хур<br>тунадас болон үерийн<br>усаар угаагдан усан орчинг<br>бохирдуулах | Нефтийн бүтээгдэхүүн<br>хадгалах технологийн<br>горимыг чанд мөрдөж<br>ажиллах, асгаралт болсон<br>тохиолдолд саармагжуулах<br>арга хэмжээг яаралтай авах,<br>саармагжуулах хэрэгслийг<br>талбайд бэлэн байлгах. | Төслийн<br>талбайд    |    | -                                                                   | -              | 2026 онд үйл<br>ажиллагааны турш<br>өдөр бүр хяналт<br>тавьж ажиллана.                                           | MNS0900:1992 -<br>Ундны ус. Эрүүл<br>ахуйн шаардлага,<br>чанар, аюулгүй<br>байдлын үнэлгээ.                                         |
| <b>Зардлын дүн</b>                                 |                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                  |                       |    |                                                                     | <b>500.0</b>   |                                                                                                                  |                                                                                                                                     |
| <b>Газрын гадарга, хэвлий болон хөрсөн бүрхэвч</b> |                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                  |                       |    |                                                                     |                |                                                                                                                  |                                                                                                                                     |
| 6                                                  | Нөлөөллийн бүсийн<br>хүрээний зам талбайн<br>тохижилт муугаас үүдэн<br>машин техник, хүний хөлөөр<br>хөрсөн бүрхэвч<br>доройтох                   | Нягтаршиж бохирдсон<br>талбайг тэгшлэн<br>сийрэгжүүлж<br>ургамалжуулах                                                                                                                                           | Төслийн ойр<br>орчим  |    | 500.0                                                               | 500.0          | 2026 оны 03-р<br>улиралд тухайн<br>жилийн батлагдсан<br>уулын ажлын<br>төлөвлөгөөтэй<br>уялдуулж<br>хэрэгжүүлнэ. | MNS 5916-2008<br>“Газар шорооны<br>ажлын үеийн<br>үржил шимт хөрс<br>хуулалт,<br>хадгалалт”,                                        |
| 7                                                  | Хүнд даацын машин<br>механизмын нөлөөгөөр<br>хөрсөн бүрхэвч элэгдэж,<br>эвдрэлд орох, сул шороо<br>ихээр үүсэх                                    | Замын усалгааг тоосжилт<br>ихтэй үеүдэд хийж байх                                                                                                                                                                | Төслийн<br>талбайд    | м² | Агаарын чанарын<br>2-р хэсэгт зам<br>усалгааны талаар<br>тусгагдсан | -              | 2026 онд<br>07-р сараас 09-р сар<br>хүртэл бороотой<br>өдрөөс бусад<br>өдрүүдэд тогтмол                          | MNS 5914:2008<br>Байгаль орчин.<br>Эвдэрсэн газрын<br>нөхөн сэргээлт.<br>Нэр томьёо,<br>тодорхойлолт Хог<br>хаягдлын тухай<br>хууль |
| 8                                                  | ШТМ болон нефтийн<br>бүтээгдэхүүний асгаралтаас<br>хөрс бохирдох                                                                                  | Засварын цех, ШТС зэргийн<br>талбайг цементлэх                                                                                                                                                                   | Төслийн<br>талбайд    | м² | 750.0                                                               | 750.0          | 2026 оны 07-р сарын<br>15-нд хэрэгжүүлнэ.                                                                        |                                                                                                                                     |
| 9                                                  | Тос тосолгооны материал<br>асгарч хөрс бохирдуулах                                                                                                | Техникийн эвдрэл гэмтлийг<br>зориулалтын талбайд<br>байрлуулж засах                                                                                                                                              | Төслийн<br>талбайд    | ш  | Өдөр тутмын үйл ажиллагаанд<br>мөрдөж ажиллана.                     |                | 2026 онд засвар<br>үйлчилгээ хийх бүрт<br>хяналт тавьж<br>ажиллана.                                              | MNS 5850-2019,<br>“Хөрсний чанар,<br>хөрс бохирдуулагч<br>бодис,                                                                    |
| 10                                                 | Уурхайн гал тогоо, угаалгаас                                                                                                                      | Хог хаягдлыг зориулалтын                                                                                                                                                                                         | Хог хаягдлын          | тн | Үйл ажиллагааны зардлаар                                            |                | 2026 онд хог үүссэн                                                                                              |                                                                                                                                     |

|                               |                                                                                                                                            |                                                                                                                             |                                                |    |                                                                           |         |                                                                                    |               |
|-------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------|----|---------------------------------------------------------------------------|---------|------------------------------------------------------------------------------------|---------------|
|                               | гарах шингэн хаягдал, хатуу хог хаягдал зэргийн нөлөөгөөр хөрс бохирдох                                                                    | саванд хадгалж нэгдсэн хогийн цэгт хаяж байх                                                                                | төлөвлөгөөнд тусгагдсан                        |    | хэрэгжүүлнэ.                                                              |         | хог хаягдлын хэмжээнээс хамааруулан сард 1-2 удаа сумын хогийн цэг рүү тээвэрлэнэ. | элементүүдийн |
|                               |                                                                                                                                            | Доторлогоотой ариун цэврийн байгууламж байгуулах                                                                            | Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгагдсан           | тн | -                                                                         |         | 2026 оны 07-р сарын 15-ны өдөр                                                     |               |
|                               | Зардлын дүн                                                                                                                                |                                                                                                                             |                                                |    | 1,250.0                                                                   |         |                                                                                    |               |
| Ургамлын нөмрөг, амьтны аймаг |                                                                                                                                            |                                                                                                                             |                                                |    |                                                                           |         |                                                                                    |               |
| 11                            | Төслийн үйл ажиллагаанаас ургамлын нөмрөг талхлагдан доройтох                                                                              | Төслийн талбайд олон наст ургамал тарьж, зүлэгжүүлэх, мод тарих ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хийж гүйцэтгэх | Төслийн талбайд                                | м² | Нөхөн сэргээлтийн зардалд орсон                                           |         | 2026 оны 10-р сарын 20-ны өдөр                                                     |               |
|                               |                                                                                                                                            | Уурхайн ажлын үед эвдэрсэн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу гүйцэтгэх                   | Нөлөөлөлд өртсөн талбайд                       | га | Нөхөн сэргээлтийн зардалд орсон                                           |         | 2026 оны 07-10-р сарын хооронд                                                     |               |
| 12                            | Зэрлэг болон тэжээвэр амьтдын осол, эндэгдэл                                                                                               | Уурхайн талбайн бүс рүү амьтад орохыг хязгаарлах, хяналт тавих                                                              | Уурхайн бүс 1.5-2.0 км                         | Км | Зардал гарахгүй, хяналт тавьж ажиллана                                    |         | 2026 онд үйл ажиллагааны турш тогтмол хяналттай ажиллана.                          |               |
|                               | Зардлын дүн                                                                                                                                |                                                                                                                             |                                                |    | -                                                                         |         |                                                                                    |               |
| Нийгэм эдийн засаг            |                                                                                                                                            |                                                                                                                             |                                                |    |                                                                           |         |                                                                                    |               |
| 13                            | Төслийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлж зөв ойлголт өгөөгүйгээс олон нийтийг төөрөгдүүлэх, сөрөг сэтгэгдэл төрүүлэх | Уурхайн ашиглалттай холбоотой иргэдээс ирэх санал гомдлыг шийдвэрлэх                                                        | Хорооны иргэд, нөлөөллийн бүсийн оршин суугчид | -  | Зардал тодорхойгүй. Шаардлагатай тохиолдолд нэмэлт зардлаар санхүүжүүлнэ. |         | 2026 онд үйл ажиллагааны турш тогтмол хяналттай ажиллана.                          |               |
|                               |                                                                                                                                            | Төслийн үйл ажиллагаа, байгаль хамгаалах чиглэлээр хийгдэж буй ажлуудыг олон нийтэд сурталчлах                              | Хороо, дүүргийн иргэд, Сонирхогч талууд        | -  | 250.0                                                                     | 500.0   | 2026 оны 08-р сарын 01 болон 10-р сарын 01-ны өдөр                                 |               |
|                               | Зардлын дүн                                                                                                                                |                                                                                                                             |                                                |    |                                                                           | 500.0   |                                                                                    |               |
|                               | Нийт зардал                                                                                                                                |                                                                                                                             |                                                |    |                                                                           | 3,750.0 |                                                                                    |               |

### 3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Галт үнэг” ХХК нь 309.32 га талбай бүхий MV-021082 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нийтдээ 5.50 га талбайд нь олборлолтын үйл ажиллагаа явуулна. Мөн хаягдлын далан, шимт хөрсний овоолго, уурхайн дотоод тээврийн зам, ажилчдын кемп зэрэг бусад үйл ажиллагаанд өртөх талбайн хэмжээ нь 1.80 га байна. Уурхайн олборлолтын болон бусад үйл ажиллагаанд өртөх нийт талбайн хэмжээ нь 7.30 га байна. Эдгээр нөлөөлөлд өртсөн талбайнуудад нөхөн сэргээлтийн арга хэмжээг уурхайн ашиглалтын үйл ажиллагаатай зэрэгцүүлэн тодорхой дэс дараалалтайгаар, тухай бүрд нь хэрэгжүүлж ажиллана.

#### Хүснэгт №17. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

| № | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээх арга хэмжээ                                      | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг, мян.төг      | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж                 | Баримтлах стандарт, аргачлал                                                                                                                                                                                                                                                                                               |
|---|--------------------------|----------------------------------------------------------------|----------------------------|-----------------------------|----------------------|------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Техникийн нөхөн сэргээлт | Шимт хөрс хуулалт, хадгалалт                                   | 9.52 мян.м³                | Уурхайн ашиглалтын зардлаар |                      | 2026 онд уулын ажил эхлэхийн өмнө              | MNS 5916:2008- Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт, MNS 5917:2008- Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага, MNS 5918:2023- Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага. |
|   |                          | Ил уурхайн нөхөн дүүргэлт хийх                                 | 5.50 га                    | 2,780.0                     | 15,295.0             | 2026 онд ашиглалтын явцтай зэрэгцэн            |                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|   |                          | Нөхөн дүүргэсэн талбайг хэвгийжүүлэх, хэлбэржүүлэх             | 5.50 га                    | 500.0                       | 2,750.0              |                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|   |                          | Хэлбэржүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих                       | 5.52 га                    | 1,140.0                     | 6,290.0              |                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|   |                          | Хаягдлын далангийн техникийн нөхөн сэргээлт                    | 0.68 га                    | 3,010.0                     | 2,060.0              | 2026 онд 10-р сарын 25                         |                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|   |                          | Овоолго, зам, байгууламжуудын талбайн техникийн нөхөн сэргээлт | 1.12 га                    | 1,200.0                     | 1,340.0              | 2026 уулын ажилтай уялдуулан хэрэгжүүлнэ.      |                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 2 | Биологийн нөхөн сэргээлт | Ил уурхайн шимт хөрсөөр хучсан талбайг ургамалжуулах           | 5.50 га                    | 1,400.0                     | 7,710.0              |                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|   |                          | Хаягдлын далангийн талбайг ургамалжуулах                       | 0.68 га                    | 1,390.0                     | 955.0                |                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|   |                          | Овоолго, зам, байгууламжуудын талбайг ургамалжуулах            | 1.12 га                    | 1,400.0                     | 1,570.0              |                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| - | Нийт дүн                 |                                                                |                            |                             | 37,970.0             | Гучин долоон сая есөн зуун далан мянган төгрөг |                                                                                                                                                                                                                                                                                                                            |

### 3.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал байхгүй байна.

### 3.4. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

### 3.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Сөрт” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.4.6-т газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ гэж заасны дагууд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэх хугацаа нь ердөө 2 жил байгаа тул дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ төлөвлөхөөс илүүтэйгээр хаалтын ажлыг чанартай гүйцэтгэл сайтай хийж орон нутагт хүлээлгэн өгөх хэрэгтэй.

Дүйцүүлэн хамгааллын зардал тооцох аргачлалаар тооцоход нэг жилийн зардлын хэмжээ 5.0 сая төгрөг болж байна.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд төслийн талбайн баруун хойд хэсэгт өмнө нь эвдрэлд өртсөн нийт 9.6 га талбайг ашиглалтын жилүүдэд хэсэгчлэн нөхөн сэргээхээр төлөвлөлөө. Үүнээс 2026 онд 4.8 га талбайд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн.



Зураг № 2. Дүйцүүлэн хамгааллаар нөхөн сэргээх талбайн байдал

### 3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад гэнэтийн осол эрсдэл гарахаас сэргийлж ажиллах шаардлагатай. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 8,940,000₮ (Найман сая есөн зуун дөчин мянган төгрөг) зарцуулах шаардлагатай гэж тооцооллоо.

Хүснэгт №18. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

| Төрөл                       | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ                                                                                                                                         | Нэгжийн зардал, мян. төг              | Нийт зардал, мян.төг   | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж                            | Баримтлах стандарт, аргачлал                                                                                                                     |
|-----------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------|------------------------|-----------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Байгалийн гамшигт үзэгдлүүд | Эрх бүхий байгууллагаар Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэнэ.                                                                                                                               | ХАБЭА-н зардалд хамаарна              | Үйл ажиллагааны зардал | 2026 оны 07-р сарын 15                                    | Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолын хавсралт Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ |
| Газар хөдлөл                | Орон нутгаас зохион байгуулах газар хөдлөлийн аюулын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний талаарх мэдлэг өгөх сургалт хөтөлбөр болон турших дасгал сургуулилалтад ажилчдыг хамруулах | 400.0                                 | 400.0                  | 2026 оны 07-р сарын 15                                    | Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/                                                                                            |
| Үер                         | Төслийн эзэмшил талбайг хаврын шар ус, хур бороо элбэгтэй үед үерт автахаас сэргийлж ус зайлуулах суваг хоолой, даланг технологийн дагуу хийх                                               | Хөрөнгө оруулалтын зардлаар байгуулна | Үйл ажиллагааны зардал | 2026 онд үйл ажиллагааны турш тогтмол хяналттай ажиллана. | MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага.                                                                      |
| Гал түймэр                  | Галын аюулын талаар анхааруулга самбарыг шинээр барьж буй объект бүрд онцлогийг нь тусган тавих. Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдэл, галын сарайг бэлэн байлгах.                        | 0.80                                  | 400.0                  | 2026 оны 07-р сарын 15                                    |                                                                                                                                                  |
| Халдварт өвчин              | Хоолны газрын эрүүл ахуйг сахиулах, ажилчдын хувийн эрүүл ахуйг сахиулах дадал зуршлыг хэвшүүлэх талаар мэдээлэл олгох сургалт зохион байгуулах                                             | 0.40                                  | 200.0                  | 2026 оны 07-р сарын 15                                    |                                                                                                                                                  |

|                                        |                                                                                                                                                  |                          |                |                                            |                                                                                                                                                                                                                  |
|----------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|----------------|--------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Үйл ажиллагааны осол гэмтэл            | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах                                                                                            | ХАБЭА-н зардалд хамаарна | -              | 2026 оны 07-р сарын 15 болон 09-р сарын 20 | MNS 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага.                                                                                                                                                |
|                                        | Бүх ажилчдад ажил эхлэхийн өмнө хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, хамрагдаагүй ажилчдыг тухайн өдөрт ажиллахыг хориглох | Зардал гарахгүй          | -              | 2026 онд үйл ажиллагааны турш тогтмол      | MNS ISO 13688:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага.                                                                                                             |
|                                        | Анхан тусламжийн багаж, эмийн санг шинэ ажилчдын байранд байрлуулах                                                                              | 2.00                     | 1,000.0        | 2026 онд уурхайн үйл ажиллагаа эхлэх үед   | MNS 4992:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.                                                                                   |
| Тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл гарах | Тоног төхөөрөмжийг тогтмол шалгаж засвар үйлчилгээг тогтмол хийх, бүртгэл хөтлөх.                                                                | -                        | -              | Үйл ажиллагааны туршид тогтмол             | Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16.1.7<br><br>MNS 5566:2020 Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм. |
| <b>Нийт зардал</b>                     |                                                                                                                                                  |                          | <b>2,000.0</b> |                                            |                                                                                                                                                                                                                  |

### 3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Сөрт” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаасаа гарч буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2017/ болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаалаар батлагдсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”, “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-д тус тус зааснаар төсөл хэрэгжүүлэгч “Галт үнэг” ХХК нь дараах үүргийг хүлээнэ.

Үүнд:

- ✓ *Хог хаягдлаа эрх бүхий байгууллагаар “Хог ачиж, тээвэрлүүлэх гэрээ”-ний дагуу ангиллын төрөл тус бүрээр нэгдсэн хогийн цэг рүү ачуулах*
- ✓ *Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад гэрээ байгуулан шилжүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх*
- ✓ *Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх*
- ✓ *Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр 180 хоногоос дээш хугацаанд түр хадгалах тохиолдолд тусгай зөвшөөрөл авч, түр хадгалахдаа Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 33-р зүйлд заасан шаардлагыг баримтална.*
- ✓ *Байгууллагын ажилтнуудад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;*
- ✓ *Орчны 50 м хүртэлх нийтийн эдэлбэр газар, зам талбайн хог хаягдал, шарилж, лууль зэрэг ургамал, цас мөсийг тогтмол цэвэрлэх.*
- ✓ *Бүх нийтийн их цэвэрлэгээнд ажилтан, албан хаагчдыг хамруулах, холбогдох зардлыг гаргаж цэвэрлэгээний багаж хэрэгслээр хангах;*
- ✓ *Бүх нийтийн их цэвэрлэгээний өдрүүдэд орон нутгийн захиргаанаас зураглалаар хариуцуулсан нийтийн эдэлбэр газар, гудамж, зам, талбайн хог хаягдлыг цэвэрлэж, холбогдох байгууллагад хүлээлгэж өгөх*
- ✓ *Энгийн хог хаягдлыг хамгийн багадаа 3 төрлөөр буюу 1. Дахин боловсруулах боломжтой, 2. Дахин боловсруулах боломжгүй, 3. Хүнсний органик хог хаягдал гэж төрөлжүүлэн эх үүсвэр дээр ангилан ялгах;*
- ✓ *Картон цааснаас бусад төрлийн ангилсан хаягдлыг зориулалтын уутанд хийж, уутны амыг боож битүүмжлэн шаардлага хангасан хогийн сав, бункерт байршуулан хадгалах ба хог ачиж цуглуулах хуваарийн дагуу ангиллын төрөл тус бүрээр хог тээврийн авто машинд ачуулах;*
- ✓ *Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах төрлийг хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагаатай уялдуулан төсөл хэрэгжүүлэгч өөрийн санаачилгаар нэмэгдүүлэх*
- ✓ *0.75 м<sup>3</sup>-с дээш эзлэхүүнтэй овор хэмжээ их энгийн болон барилгын хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-д заасны дагуу нэмэлт үйлчилгээний хөлс төлж эрх бүхий мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлэх;*

Хүснэгт №19. Хог, хаягдайн менежментийн төлөвлөгөө

| № | Хог, хаягдлын ангилал | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ                                                                                                        | Нийт зардал, сая төг                               | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж<br>Зардал, мян.төг |                                                                       | Баримтлах стандарт, аргачлал                                                                                                                                                                                                                                     |
|---|-----------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|---------------------------------------------------|-----------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   |                       |                                                                                                                                                            |                                                    | 2026                                              | Давтамж                                                               |                                                                                                                                                                                                                                                                  |
| 1 | Ахуйн хог, хаягдал    | Хог хаягдал түр хадгалах цэг, ангилан ялгалттай хогийн савыг байрлуулах, тогтмол шинэчлэх                                                                  | 1.0                                                | 500.0                                             | 2026 оны 07-р сарын 15                                                | Хог хаягдлын тухай хууль;<br><br>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/349 дугаар тушаалын хавсралт. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл;                                           |
|   |                       | Хог хаягдал түр хадгалах цэг орчимд тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх                                                                                      | 0.5                                                | 250.0                                             | 2026 оны 07-10 сар                                                    |                                                                                                                                                                                                                                                                  |
|   |                       | Хог хаягдлыг ангилан ялгаж, гэрээт ААН-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх                                                                         | 250.0                                              | 500.0                                             | 2026 оны 08-р сарын 03 болон 10 сарын 10                              |                                                                                                                                                                                                                                                                  |
|   |                       | Ажилчдад хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах талаар дадал зуршил эзэмшүүлэх сургалт орох, мэдээллийн самбарт мэдээлэл байршуулах                         | 0.5                                                | 250.0                                             | 2026 оны 07-08-р сард                                                 |                                                                                                                                                                                                                                                                  |
| 2 | Аюултай хог, хаягдал  | Машин техникийн төмөр сэлбэг хэрэгсэл болон дугуйн хаягдлыг тусгай талбайд хуримтлуулан дахин боловсруулах үйлдвэрт өгөх                                   | Ялгаралтын хэмжээнээс хамаарч гэрээгээр гүйцэтгэнэ | -                                                 | 2026 онд үйл ажиллагаа зогсох үед цугларсан төмрийн хаягдлыг тушаана. | MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;<br><br>Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам, |
|   |                       | Машин техникээс гарсан ШТМ, тос тосолгооны материалын сав баглаа боодол, ШТМ арчсан даавуу зэргийг аюултай хог хаягдлыг хадгалах, устгах цэг рүү зөөвөрлөх | Ялгаралтын хэмжээнээс хамаарч гэрээгээр гүйцэтгэнэ | -                                                 | 2026 онд үүссэн хэмжээнээс хамаарч жилд 1-2 удаа                      |                                                                                                                                                                                                                                                                  |
| - | -                     | <b>Нийт зардал</b>                                                                                                                                         | <b>3.00</b>                                        | <b>1,500.0</b>                                    | -                                                                     | -                                                                                                                                                                                                                                                                |

### 3.8. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хүснэгт №20. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ                                                                                                                                                                                                                                                                                                                            | Санхүүжилт                                    | Хэрэгжүүлэх хуваарь                                 | Хариуцсан албан тушаалтан                                              |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------|-----------------------------------------------------|------------------------------------------------------------------------|
| 1 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх                                                                                                                                                                                               | Менежментийн үйл ажиллагаа                    | 2026 оны 07-р сарын 15-аас 08-р сарын 01-ны хооронд | Удирдлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн |
| 2 | Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийн дагуу хог хаягдлын төрөл, кодыг тогтоон ялгаж бүртгэл хөтлөх                                                                                                                                                                                                            |                                               |                                                     |                                                                        |
| 3 | Байгаль орчныг хамгаалах, осол, гал түймэр, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалтыг мэргэжлийн байгууллагын хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах                                                                                                  | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтээр |                                                     |                                                                        |
| 4 | Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж, байгууллагын удирдлага болон орон нутгийн онцгой байдлын газраар батлуулна                                                                                                                                                                                                                        |                                               |                                                     |                                                                        |
| 5 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын дүрэм боловсруулж, нутаг дэвсгэрийнхээ байгаль орчны болон эрүүл ахуйн улсын байцаагчаар хянуулж мөрдөнө.                                                                                                                                                                                         | -                                             |                                                     |                                                                        |
| 6 | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах                                                                                                                                                                                                                                                                                        | ХАБЭА-н зардалд хамаарна                      | 2026 оны 07-р сарын 20 болон 09-р сарын 01-нд       |                                                                        |
| 7 | <a href="#">Байгаль орчныг хамгаалах тухай</a> хуулийн 2-р бүлгийн 10 <sup>1</sup> дүгээр зүйлийн 1-д заасны дагуу Байгаль орчны аудитыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа Өвөрхангай аймгийн Байгаль орчны газарт хүргүүлэх | Үнийн саналаар                                | 2026 оны 08-р сарын 01-ээс 20-ны хооронд            | Удирдлага, Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн |
| 8 | Эзэмшлийн газарт газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг 5 жил тутамд эрх бүхий байгууллагаар хийлгэж байх                                                                                                                                                                                                                              | Үнийн саналаар                                | 2026 оны 07-р сарын 20-оос 08-р сарын 20-ны хооронд | Удирдлага, Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн |


### 3.9. Орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт № 21. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

| Хянах үзүүлэлтүүд                                                                                                                | Хяналт, шинжилгээ хийх байршил                                                                                                                                                                | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо                  | Нэгжийн зардал, мян.төг | Нийт зардал, мян.төг | Тайлбар                                                                                      | Баримтлах стандарт ба аргачлал                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|---------------------------------|-------------------------|----------------------|----------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Агаарын чанар                                                                                                                    |                                                                                                                                                                                               |                    |                                 |                         |                      |                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| Тоосжилт (PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> ); орчны дуу чимээ;<br>Агаар бохирдуулагч хий NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> ; | Салхины зонхилох чиглэл болон эх үүсвэрүүдийн байршил дахь агаар бохирдуулагчийн тархалтыг гаргахад төлөөлөх чадвартай 3 цэгт (Авто машины зогсоол, ажилчдын оффис, терминалын талбай орчимд) | Жилд нэг удаа      | 1 удаа /2026 оны 08-р сарын 10/ | 200.0                   | 600.0                | Эх үүсвэрүүдийн байршил, нөлөөллийн түвшин зэрэгт тулгуурлан төслийн талбайд арга зүйн дагуу | MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага;<br>MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ;<br><br>MNS3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга;<br>MNS5885-2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага;<br><br>MNS0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга;<br>MNS0012-1-015:1987. Чимээ шуугиан—Ажлын байрны чимээ шуугианыг хэмжих арга;<br><br>MNS0017.2.5.12:1988. Байгаль хамгаалал. Агаар мандал. Агаар дахь хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга;<br><br>MNS0017.2.5.11-1988. Байгаль хамгаалал. Агаар мандал. Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга;<br>MNS5365:2004 Агаарын чанарын ерөнхий асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга; |

| Хөрсөн бүрхэвч                                                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                             |                                                                 |                                 |                  |       |                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                            |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------|---------------------------------|------------------|-------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат ( $\text{CaCO}_3$ ), хөдөлгөөнт кали ( $\text{K}_2\text{O}$ ), хөдөлгөөнт фосфор ( $\text{P}_2\text{O}_5$ ), механик бүрэлдэхүүн Хар тунгалаг (Pb), кадми (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), Мөнгөн ус (Hg), цианид натри, хүнцэл (As) | Хогийн цэг, цэвэрлэх байгууламж, хөрсний овоолго, зогсоолын талбай, ЗҮТ, тээврийн зам дагуу уулын хэсэг, болон хашааны гадна талд нийт цэгт | Жилд 1 удаа 4 цэгт дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө. | 1 удаа /2026 оны 08-р сарын 10/ | 100.0 нэг дээжид | 400.0 | Итгэмжлэгдсэн лабораторийн дэлгэрэнгүй шинжилгээ                                                                                                         | MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам;<br><br>MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд;<br><br>MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ; |
| Ургамлан нөмрөг                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                             |                                                                 |                                 |                  |       |                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                            |
| Ургамлын зүйлийн тоо, арви бүрхэц, төслийн гаднах талбайн биомасс зэргийг гаргана.                                                                                                                                                                                                          | Төслийн талбайд орших ургамлан нөмрөг бүхий талбай болон төслийн талбайн гадна                                                              | Төсөл хэрэгжилтийн явцад жил бүр 1 удаа                         | 1 удаа /2026 оны 08-р сарын 10/ | 300.0            | 300.0 | Дижитал зургийн аппарат, хээрийн судалгааны мэдээ цуглуулах маягтууд, харандаа, туузан метр, хатгуур, төмөр гадас, ашиглан тооллого, хэмжилт хийх аргаар | Ургамлын бичиглэл хийх аргачлал                                                                                                                                                                                                            |
| Амьтны аймаг                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                             |                                                                 |                                 |                  |       |                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                            |

|                                                                        |                           |                                                           |                                                              |       |       |                                                                                                                              |                                                                           |
|------------------------------------------------------------------------|---------------------------|-----------------------------------------------------------|--------------------------------------------------------------|-------|-------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------|
| Шувууд,<br>мөлхөгчид, хөхтөн<br>амьтдыг ажиглах,<br>тоо толгойг гаргах | Төслийн талбайд<br>орчимд | Төсөл<br>хэрэгжилтийн<br>явцад жил<br>бүр 1 удаа          | 2 удаа<br>/2026 оны 08-р<br>сарын 10 болон<br>09-р сарын 20/ | 100.0 | 200.0 | Ажиглалтын<br>арга, Дуран,<br>дигитал<br>зургийн<br>аппарат,<br>байршил<br>тогтоогч<br>(GPS),<br>судалгааны<br>маягт ашиглах | Биологийн олон янз байдлын мониторинг<br>судалгааны арга зүй. БОНХЯ, 2012 |
| <b>Нийт зардал</b>                                                     |                           | <b>1,500.0 мян.төг (Нэг сая таван зуун мянган төгрөг)</b> |                                                              |       |       |                                                                                                                              |                                                                           |



Зураг № 3. Хөрс, ургамлын мониторингийн цэгүүдийн байршлын зураг

### 3.10. “Тэр бум” мод Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

| № | Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээний төлөвлөгөө        | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн зардал, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах стандарт ба аргачлал  |
|---|----------------------------------------------------------------|-------------|------------|-------------------------|----------------------|------------------------------|---------------------------------|
| 1 | Ажилчдын хотхоны гадна хайлаас мод суулгацаар шуудуулан тарина | ш           | 100        | 3,000.0                 |                      | 2026 оны 10 сард             | “Тэр бум” мод Үндэсний хөтөлбөр |
|   | <b>Нийт зардал</b>                                             |             |            | <b>3,000.0</b>          |                      |                              |                                 |

### 3.11. БОМТ-ний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Хүснэгт № 22. БОМТ-ний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

| БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд                 | Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр                                                                                                                                         | Мэдээллийн агуулга                                                                                              | Хугацааны тов                           | Тайлагнах зардал, мян.төг | Хэлэлцүүлгээр санал авах чиглэл                                                                | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан эсвэл ажилтан | Зохион байгуулах газар                  |
|------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------|---------------------------|------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------|-----------------------------------------|
| Төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин аялал жуулчлалын яам/ | БОМТ-ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ. | Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн бичвэр байна. | Жил бүрийн 12 дугаар сарын 30-наас өмнө | -                         | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн баталгаажуулах орчны тайланг             | Удирдлага, байгаль орчны ажилтан                        | БОУАӨЯ-д                                |
| Өвөрхангай аймгийн Байгаль орчны газар                                 | Тайлангийн эх хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт                                                                                                           | Тухайн бичвэр ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна.                             | Жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс өмнө |                           | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг санал авах                               |                                                         | Өвөрхангай аймгийн байгаль орчны газарт |
| Тарагт сумын ЗДТГ-т                                                    | БОМТ-ний хэрэгжилтийн тайланг иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах                                                                                       |                                                                                                                 | Жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс өмнө |                           | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах |                                                         | Өвөрхангай аймгийн Тарагт сумын ЗДТГ-т  |
| <b>Нийт зардал</b>                                                     |                                                                                                                                                                       |                                                                                                                 |                                         | <b>-</b>                  |                                                                                                |                                                         |                                         |

### 3.12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

| №                    | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө                                                    |                                                                             | Нийт зардал<br>мян.төг |
|----------------------|------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------|------------------------|
| 1                    | Байгаль орчныг<br>хамгаалах<br>төлөвлөгөө                                                | Сөрөг нөлөөллийг буруулах арга<br>хэмжээний төлөвлөгөө                      | 3,750.0                |
|                      |                                                                                          | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө                                                | 37,970.0               |
|                      |                                                                                          | Биологийн олон янз байдлын дүйцүүлэн<br>хамгаалах төлөвлөгөө                | 5,000.0                |
|                      |                                                                                          | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох<br>төлөвлөгөө                        | -                      |
|                      |                                                                                          | Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө                                     | -                      |
|                      |                                                                                          | Осол, эрсдэлийн менежментийн<br>төлөвлөгөө                                  | 2,000.0                |
|                      |                                                                                          | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө                                       | 1,500.0                |
|                      |                                                                                          | Удирдлага, зохион байгуулалтын авч<br>хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө | -                      |
| 2                    | Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр                                                      |                                                                             | 1,500.0                |
| 3                    | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих<br>ажлын төлөвлөгөө                  |                                                                             | 3,000.0                |
| 4                    | БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад<br>тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь |                                                                             | -                      |
| Нийт зардал, сая төг |                                                                                          |                                                                             | 54,720.0               |

Тус төслийг хэрэгжүүлэх ашиглалтын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **54,720,000** төгрөгийг төлөвлөсөн.